



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 110

Улаанбаатар хот

БОГД ХАН ХАЙРХАН УУЛ, ХАН ХЭНТИЙ УУЛ, ОТГОНТЭНГЭР УУЛЫГ ТАЙХ УЛАМЖЛАЛЫГ

СЭРГЭЭХ САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ТУХАЙ

1.Монголчууд эртнээс нааш Богд хан хайрхан уул, Хан Хэнтий уул, Отгонтэнгэр уулыг тахиж ирсэн уламжлалыг сэргээн дээрх уулсыг Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт заасныг харгалзан эдүгээ цагийн байдалд нийцүүлэн тайх талаар олон түмнээс гаргаж байгаа санаачилгыг дэмжсүгэй.

2.Хан Хэнтий уулыг тайхад Чингис хааны зарлигийг уламжлуулан дагаж Монгол Улсын бүх цэргийн хар сүлдийг цэнгүүлэн тахиж ёслолыг хамтатган гүйцэтгэх нь зүйтэй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.ОЧИРБАТ